



**ХЭНТИЙ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/14

Чингис хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн хоёрдугаар хуралдааны 08 дугаар тогтоолыг үндэслэн ТУШААХ нь:

1. Хэрлэн сумын Эрүүл мэндийн төвд авто машин нийлүүлэх ажлыг хүлээн авах комиссыг доорх бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Г.Лхагвахатан Аймгийн Засаг даргын Тамгын газрын
Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Д.Баттунгалаг "Ач манал" Өрхийн эрүүл мэндийн төвийн
нярав

Гишүүд: Э.Шинэбаяр "Ач манал" Өрхийн эрүүл мэндийн төвийн
жолооч

2. Ажлыг техникийн тодорхойлолтод заасан шаардлагын дагуу хүлээн авахыг комиссын дарга /Г.Лхагвахатан/-д даалгасугай.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030101